



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/113

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүүрмийн 3.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Булган сумын Бүрэнхайрхан багийн нутаг дэвсгэрт “Экстракт” ХХК-ний хийж гүйцэтгэсэн Соёлын төвийн их засварын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Тогтохбаяр	-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын хэлтсийн дарга
Гишүүд:	С.Өнөржаргал	-Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн
	З.Өмиртай	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын материалын үйлдвэрлэл, лаборатори хариуцсан мэргэжилтэн
	С.Чанцал	-Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч
	Г.Ганжаргал	-Онцгой байдлын газрын гал түймрийн Улсын байцаагч
	Б.Амарзаяа	-Барилгын хөгжлийн төвийн захиалагчийн хяналтын ахлах инженер
	Э.Маргадэрдэнэ	-Барилгын хөгжлийн төвийн хяналтын инженер

- Б.Оюунбилэг - Барилгын хөгжлийн төвийн хяналтын инженер
- Н.Гомбосүрэн - Барилгын хөгжлийн төвийн хяналтын инженер
- Б.Амгаланбадрах -Булган сумын Засаг дарга
- Д.Мөнхдалай -Булган сумын Соёлын төвийн дарга
- Б.Ганбаатар -“Экстракт” ХХК-ний захирал
- Г.Дуламсүрэн - “Чулуутын багш” ХХК-ний захирал
- С.Батдорж -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга

Нарийн бичгийн дарга:

- Б.Одсүрэн -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Булган сумын Бүрэнхайрхан багийн нутаг дэвсгэрт “Экстракт” ХХК-ний хийж гүйцэтгэсэн Соёлын төвийн их засварын ажлыг зураг,төсвийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Тогтохбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН